



**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
ГҮЙЦЭТГЭЛ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗАР**

**МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ
2021-2024 ОНД 67.7 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА**

Аудитын сэдэв: Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

Аудитын код: ГНАГ-2025/04-ШТА-ГА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх
аудитор Д.Энхболд

Утас: 263755, Цахим хаяг: enkhboldd@audit.gov.mn

Аудитын менежер Б.Сандуйжав

Утас: 261639, Цахим хаяг: sanduijavb@audit.gov.mn

Ахлах аудитор М.Сангижанцан

Утас: 261745, Цахим хаяг: sangijantsanm@audit.gov.mn

Аудитор Ш.Наранбаатар

Цахим хаяг: naranbaatarsh@audit.gov.mn

Аудитор Ж.Чинбат

Цахим хаяг: chinbatj@audit.gov.mn

Аудитор А.Мөнхбадрал

Цахим хаяг: munkhbadrala@audit.gov.mn

Аудитор С.Оюун-Эрдэнэ

Цахим хаяг: oyun-erdenes@audit.gov.mn

Аудитор С.Номин-Эрдэнэ

Цахим хаяг: nomin-erdenes@audit.gov.mn

Аудитор А.Төгөлдөр

Цахим хаяг: tuguldura@audit.gov.mn

Улаанбаатар хот. 2025 он



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2025 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1."Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2.Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Эдийн засгийн Байнгын хороо, Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Эдийн засаг, хөгжлийн яаманд тус тус хүргүүлэхийг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т даалгасугай.

3.Аудитаар өгсөн зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан хугацаанд, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга (Н.Учрал), Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд, Эдийн засаг, хөгжлийн сайд (Л.Гантөмөр), Төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус зөвлөсүгэй.

4.Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар (Д.Энхболд)-т үүрэг болгосугай.

5.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч (Я.Самбууням)-д даалгасугай.

Д ЗАГДЖАВ

Z:\Tushaal\2025\EA-In A Tushaal\0313 GN\AG-1.Door

1525010092

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн жагсаалт	3
Дүрслэлийн жагсаалт	3
Хавсралтын жагсаалт	3
Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх	4
Аудитын зорилго	4
Аудитын хамарсан хүрээ	4
Аудитын арга зүй	4
Аудитын шалгуур үзүүлэлт	4
Аудитын багийн бүрэлдэхүүн	5
БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭМЖИГДЭХҮЙЦ, ХҮРЧ БОЛОХУЙЦ, БОДИТОЙ БУС, ХАРИУЦАХ ЭЗЭНГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА	8
Үндсэн чиглэлийг урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулсан байна	8
Үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна	8
БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 67.7 ХУВЬ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР 61.7 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА 16	
“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээг богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэх үйл явц хангалтгүй байна	16
Үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой, үнэн зөв тайлагнаж, үнэлээгүй байна	20
ДҮГНЭЛТ	33
ЗӨВЛӨМЖ	34
ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ	36

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АТГ	Авлигатай тэмцэх газар
АҮЭБЯ	Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам
АХ	Арга хэмжээ
БОУАӨЯ	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам
БТСУХ	Биеийн тамир, спортын улсын хороо
БХЯ	Батлан хамгаалах яам
БЯ	Боловсролын яам
ГА	Гүйцэтгэлийн аудит
ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ГЗБГЗЗЕГ	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар
ГНАГ	Гүйцэтгэл, нийцлийн аудитын газар
ГХЯ	Гадаад харилцааны яам
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ЗТЯ	Зам, тээврийн яам
МБ	Монгол банк
МУХТЖҮЧ	Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл
НЗДТГ	Нийслэлийн засаг даргын Тамгын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СХЗГ	Стандарт, хэмжил зүйн газар
СЯ	Сангийн яам
ТАЗ	Төрийн албаны зөвлөл
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үндэслэл
ТХААГ	Төрийн худалдан авах ажиллагааны газар
УИХ	Улсын Их Хурал
УХЖТ	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ҮСХД	Үндэсний статистикийн хорооны дарга
ХББОСЯ	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЭҮК	Хүний эрхийн үндэсний комисс
ЦХИХХЯ	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ШСАА	Шадар сайдын ажлын алба
ШТА	Шууд тайлагнах ажил
ЭЗХС	Эдийн засаг, хөгжлийн сайд
ЭЗХЯ	Эдийн засаг, хөгжлийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭХЯ	Эрчим хүчний яам

Хүснэгтийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн хуваарилалт	6
Хүснэгт 2	Төслийн ач холбогдлын үнэлгээ, хэрэгжих боломжийн үнэлгээг хийсэн байдал	13
Хүснэгт 3	Зарим арга хэмжээний суурь, хүрэх түвшин, үр дүнгийн харьцуулалт	20
Хүснэгт 4	Үндсэн чиглэлд туссан бодлого, зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн үнэлгээ	20
Хүснэгт 5	Үндсэн чиглэлд туссан зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн үнэлгээ	21
Хүснэгт 6	Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээ /хувь/	25
Хүснэгт 7	Бодлого, зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт	26
Хүснэгт 8	Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан бодлого, зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/, үнэлсэн арга хэмжээний тоо	28
Хүснэгт 9	Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан ТАХ-ний санхүүжилтийн гүйцэтгэл	28
Хүснэгт 10	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай ТАХ-ний гүйцэтгэл	29
Хүснэгт 11	Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай ТАХ-ний гүйцэтгэл	30

Дүрслэлийн жагсаалт

Дугаар	Агуулга	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Үнэлгээ хийгээгүй шалтгааны ангилал	13
Дүрслэл 2	МУХТЖҮЧ-ийн УХЖТ болон Төсвийн тухай хуулийн уялдаа	16
Дүрслэл 3	Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн УХЖТ болон Төсвийн тухай хуулийн уялдаа	17
Дүрслэл 4	УХЖТ болон Төсвийн тухай хуулийн уялдаа	17
Дүрслэл 5	УХЖТ, Төсвийн тухай хуулийн уялдаа	18
Дүрслэл 6	ТАХ-ний хэрэгжилтийн байдал, /бодлогоор/	18
Дүрслэл 7	Бүрэн хэрэгжээгүй ТАХ, /шалтгаанаар/	19
Дүрслэл 8	2024 оны байдлаар хүрсэн түвшнийг тооцсон байдал	19
Дүрслэл 9	ТАХ-ний гүйцэтгэл, бодлогын ангиллаар	27
Дүрслэл 10	Зорилтод түвшинд хүрээгүй ТАХ /шалтгаанаар/	27
Дүрслэл 11	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулаагүй байдал /шалтгаанаар/	29

Хавсралтын жагсаалт

Дугаар	Агуулга
Хавсралт 1	УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдсэн ТАХ-ний жагсаалт
Хавсралт 2	"Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-ийн арга хэмжээний хэрэгжилт
Хавсралт 3	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, стандартын мэдэгдэл

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Төрийн аудитын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.5 дахь зүйлийг үндэслэн мөн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2025 оны А/08 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г үндэслэн аудитыг хийлээ.

Аудитын зорилго

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан эсэх, жил жилийн Улсын хөгжлийн төлөвлөгөө, Төсвийн тухай хууль нь үндсэн чиглэл, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх, үндсэн чиглэл, хөтөлбөрийн хэрэгжилтийг бодитой үнэлж, гарсан үр нөлөөг тооцож зохих арга хэмжээ авсан эсэхийг тодорхойлоход аудитын зорилго чиглэгдсэн. Уг зорилгыг хангахын тулд дараах зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хууль, журамд заасан шаардлагад нийцүүлж, урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулсан эсэх;
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл болон Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлж, гүйцэтгэлийг бодитой үнэлэн, үр нөлөөг тооцсон эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитад Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлж байгаа Төсвийн ерөнхийлөн захирагч болон тэдгээрийн харьяа байгууллагууд, холбогдох бусад байгууллагуудыг хамруулан тус үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, үнэлгээний баримт материалын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Мөн Үндэсний статистикийн хорооноос хуульд заасан чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний баримт материалыг хамрууллаа.

Аудитын арга зүй

Аудитыг АДБОУС 100, 300, 400, 3000-3100, 4000, Монгол Улсын төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-6:2020 Нийцлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, MNS 6817-8:2020 Нийцлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу аудитын зорилго, зорилтод хариулт өгөхөд шаардагдах нотлох баримтыг цуглуулж, баримтжуулан, тэдгээрийг нягтлан шалгах, дүн шинжилгээ, харьцуулалт, тулган баталгаажуулалт, ярилцлага, судалгаа хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан гүйцэтгэж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах шалгуур үзүүлэлтийг ашигласан. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль,
- Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль,
- Төсвийн тухай хууль,
- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,
- Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль,

- Монгол Улсын 2021, 2022, 2023, 2024, 2025 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”,
- Монгол Улсын хөгжлийн 2022, 2023, 2024, 2025 оны төлөвлөгөө,
- Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор баталсан “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам”,
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”,
- Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын 3 дугаар хавсралтаар баталсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцох аргачлал”,
- Үндэсний хөгжлийн газрын даргын 2020 оны А-56 дугаар тушаалаар баталсан “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал”, “Төслийн санхүүгийн үр ашгийн шинжилгээ хийх аргачлал”, “Төслийн эдийн засгийн үр ашгийн шинжилгээ хийх аргачлал”,
- Холбогдох бусад хууль, эрх зүйн актууд,
- Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжүүд, тогтоосон төлбөрийн акт,
- Монгол Улсын эдийн засаг, статистикийн үзүүлэлтүүд,
- Төсөл, арга хэмжээний батлагдсан зураг төсөв, ТЭЗҮ болон бусад шаардлагууд.

Аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл, нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд удирдаж, аудитын менежер Б.Сандуйжав үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор М.Сангижанцан, аудитор Ш.Наранбаатар, Ж.Чинбат, А.Мөнхбадрал, С.Оюун-Эрдэнэ, С.Номин-Эрдэнэ, А.Төгөлдөр нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Ерөнхий мэдээлэл:

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг дараах байдлаар баталсан байна. Үүнд:

- Тогтоолын 01 дүгээр хавсралтаар “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, түүний хэрэгжилтийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг,
- Тогтоолын 02 дугаар хавсралтаар Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн, шийдвэрлэх шаардлагатай төсөл, арга хэмжээний болон техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай төсөл, арга хэмжээний жагсаалт, хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт бүхий Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг баталсан байна.

Иймд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” болон Монгол “Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг тус тусад нь гүйцэтгэлийг үнэлсэн болно.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	9 бодлого, зорилгын хүрээнд нийт 47 зорилт, 243 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.
	Хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг 95 шалгуур үзүүлэлтээр баталсан.
Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр	9 бодлого, зорилгын хүрээнд нийт 150 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй баталсан.
	Техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах шаардлагатай 98 төсөл, арга хэмжээний жагсаалт баталсан.
	Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай 88 төсөл, арга хэмжээний жагсаалт баталсан.

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийт 49,690.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 150 төсөл, арга хэмжээг 39,612.6 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Төсөл, арга хэмжээний санхүүжилтийн хуваарилалтыг харуулав.

Хүснэгт 1. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн санхүүжилтийн хуваарилалт /тэрбум төгрөг/

Бодлого, зорилгын нэр	ТАХ-ний тоо	Санхүүжилт, оноор					Нийт санхүүжилт
		2021	2022	2023	2024	2025	
Үндэсний нэгдмэл үнэт зүйл	6	190.6	135.9	50.8	-	-	377.4
Хүний хөгжил	19	620.0	589.5	468.6	424.4	21.0	2,123.6

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

Амьдралын чанар ба дундаж давхарга	14	488.9	339.6	1,216.4	169.2	94.7	2,308.8
Эдийн засаг	56	7,510.9	11,363.6	8,056.0	2,755.4	712.9	30,398.8
Засаглал	9	127.5	98.3	73.5	11.3	10.7	321.3
Ногоон хөгжил	6	134.6	129.9	212.0	179.1	53.2	708.8
Амар тайван, аюулгүй нийгэм	11	203.9	194.3	165.7	111.3	20.7	695.9
Бүс, орон нутгийн хөгжил	18	474.2	450.0	252.0	157.0	157.7	1,491.0
Улаанбаатар ба дагуул хот	11	374.7	412.2	264.6	95.7	40.1	1,187.3
Нийт	150	10,125.3	13,713.3	10,759.7	3,903.5	1,111.2	39,612.9
Үүнээс санхүүжилтийн эх үүсвэрээр							
Гадаад зээл, тусламж		3,728.6	3,653.4	4,474.3	1,634.1	594.7	14,085.2
Шууд хөрөнгө оруулалт		2,888.5	5,656.7	2,979.8	624.9	164.0	12,313.9
Хөгжлийн банкны санхүүжилт		142.5	134.4	19.1	-	-	296.0
Концесс, төр-хувийн хэвшлийн түншлэл		1,437.7	1,696.9	1,825.6	1,119.0	191.2	6,270.4
Эх үүсвэр шийдвэрлэгдээгүй		772.5	1,363.5	706.0	93.0	39.8	2,974.8
Нийслэлийн төсөв		1.6	-	0.3	0.3	0.3	2.6
Улсын төсөв		1,153.9	1,208.3	754.5	432.2	121.1	3,670.1
Нийт санхүүжилтэд улсын төсвийн эзлэх хувь		11.4	8.8	7.0	11.1	10.9	9.3

Эх сурвалж: Аудиторын тооцоолол


Дээрх санхүүжилтийн эх үүсвэрийн мэдээллээс харахад шаардлагатай санхүүжилтийн **9.3** хувийг улсын төсвөөс, дийлэнх хувийг гадаадын зээл тусламж, шууд хөрөнгө оруулалтаар шийдвэрлэхээр төлөвлөсөн байна.

БҮЛЭГ 1. МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙГ ХЭМЖИГДЭХҮЙЦ, ХҮРЧ БОЛОХҮЙЦ, БОДИТОЙ БУС, ХАРИУЦАХ ЭЗЭНГҮЙ ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА

Үндсэн чиглэлийг урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдуулан боловсруулсан байна

1.1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” нь урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн¹ байхаар тусгасан байна.

1.2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” нь “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байдлыг харуулбал:



Дээрх үзүүлэлтээс харахад “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг урт хугацааны хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулсан байна.

Үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг бүрэн хангаагүй байна

1.3. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулах үйл явцын холбогдох зохицуулалтыг дараах хууль тогтоомжид тусгасан байна. Үүнд:

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль	Үндсэн чиглэлд тавигдах шаардлагууд болон үндсэн чиглэлийн төслийг боловсруулахад тавигдах шаардлагууд, Үндсэн чиглэлд оролцогч байгууллагуудын чиг үүрэг.
Төсвийн тухай хууль	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төлөвлөлт, төсөвлөлт, төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагууд. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт оролцогч байгууллагуудын чиг үүрэг
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулах журам	Үндсэн чиглэлийг боловсруулахад баримтлах зарчим, шаардлагууд
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал	Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний ач холбогдлын болон хэрэгжих боломжийн үнэлгээний үзүүлэлтүүд

¹ 4.1.6-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн ... төлөвлөлтийн баримт бичгийг,

1.4. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг дээрх хууль тогтоомжид тусгасан шаардлагын дагуу боловсруулсан эсэхийг авч үзвэл:

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл

1.5. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.1-д “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” нь дараах шаардлагыг хангасан байхаар тусгасан байна. Үүнд:

- Урт хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтын тухайн таван жилд хүрэх үр дүн, тоон болон чанарын шалгуур үзүүлэлт, тухайн шалгуур үзүүлэлтээр хэмжигдэх зорилтот түвшнийг тодорхойлсон байх,
- Хүн, нийгэм, эдийн засгийн хөгжил, байгаль орчны тэнцвэртэй байдал, засаглалыг сайжруулахад чиглэсэн салбар болон салбар хоорондын уялдааг хангасан байх,
- Тухайн таван жилд тавьсан зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хавсаргах.

1.6. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” нь дээрх шаардлагыг хангасан эсэхийг авч үзвэл:

Шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүн, зорилтот түвшин

1.7. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшинтэй батлагдсан ч үндсэн чиглэлд тусгасан 243 АХ-тэй уялдаа багатай байна. Тодруулбал: 243 АХ-ээс 108 нь шалгуур үзүүлэлт, суурь болон хүрэх түвшингүй байна. Энэ нь хуулийн шаардлагыг бүрэн хангаагүйг харуулж байна.

Тэнцвэрт байдал, салбар хоорондын уялдааг хангасан байдал

1.8. “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг дараах 9 бодлого, зорилгын хүрээнд боловсруулсан байна. Үүнд:

- Үндэсний нэгдмэл үнэт зүйл
- Хүний хөгжил
- Амьдралын чанар ба дундаж давхарга
- Эдийн засаг
- Засаглал
- Ногоон хөгжил
- Амар тайван, аюулгүй нийгэм
- Бүс, орон нутгийн хөгжил
- Улаанбаатар ба дагуул хот

Тодорхойлсон бодлого, зорилгын хүрээнд нийт 47 зорилт, 243 арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Эдгээр арга хэмжээг холбогдох байгууллагууд бие даан болон хамтран хэрэгжүүлж байна. Энэ нь хуулийн шаардлагыг хангасан байна.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хавсаргасан байдал

1.9. “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулж баталсан байна.

1.10. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хавсралт бус буюу үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь УИХ-

ын 2020 оны “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай” 23 дугаар тогтоолын 1 болон 2 дугаар хавсралт хэлбэрээр батлагдсан байна.

1.11. Дээрх шаардлагуудаас гадна Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 11 дүгээр зүйлд хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад тавих шаардлагыг тусгасан бөгөөд энэ шаардлагыг хангасан байдлыг харуулбал:

Үзүүлэлт	Баримт бичигт тусгасан байдал
Хэрэгжүүлэх арга зам, үе шат, хүрэх үр дүн, бодлогыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгэм, байгаль орчинд бий болох үр нөлөө, эрсдэл, санхүүгийн эх үүсвэр, хариуцах байгууллагыг тусгана.	“Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д эдгээр шаардлагыг тусгаагүй байна.
Олон талын оролцоог хангасан байх ба эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлнэ.	“Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн эцэслэгдсэн төслийг олон нийтээр хэлэлцүүлээгүй байна.

Энэ үзүүлэлтээс харахад “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” нь хуулийн дээрх шаардлагыг хангаагүй байна.

Байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилт

1.12. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд² хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах үйл явцад дараах байгууллагуудын чиг үүргийг тусгасан бөгөөд хэрэгжилтийг авч үзвэл:

Төрийн захиргааны төв байгууллагууд дараах чиг үүргийг³ хэрэгжүүлэхээр тусгагдсан ба хэрэгжилт нь дараах байдалтай байна. Үүнд:

Чиг үүрэг	Чиг, үүргийн хэрэгжилт
Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах саналаа ЭЗХЯ-нд хүргүүлж, шаардлагатай тоо баримт, судалгаа, мэдээллийг хууль тогтоомжид заасан хугацаанд шуурхай гарган хүргүүлэх	ТЕЗ-чид хөгжлийн бодлогын баримт бичигт тусгах саналаа холбогдох баримт материалын хамт ЭЗХЯ /Тухайн үеийн Үндэсний хөгжлийн газар/-нд хүргүүлсэн байна.
Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын санал, тооцооллыг нэгтгэн боловсруулж ЭЗХЯ-нд хүргүүлэх	

² Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7, 9.9 дэх заалт

³ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалт

Үндэсний статистикийн хороо	•Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад шаардлагатай арга зүй, мэргэжлийн зөвлөгөөгөөр хангах, бүх үе шатанд шаардагдах статистик мэдээллийг тухай бүр боловсруулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх чиг үүрэгтэй ч энэ чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх нотлох баримтгүй байна.
Монгол банк	•Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд макро эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хангах, холбогдох санал өгөх чиг үүрэгтэй ч энэ чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх нотлох баримтгүй байна.
Сангийн яам	•Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрээр хангах чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Эдийн засаг, хөгжлийн яам (Тухайн үеийн Үндэсний хөгжлийн газар)	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулахад хууль тогтоомжид заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
---	---

1.13. ЭЗХЯ нь дараах чиг үүргийг⁴ хэрэгжүүлэхээр тусгагдсан ба хэрэгжилт нь дараах байдалтай байна. Үүнд:

Чиг үүрэг	Чиг, үүргийн хэрэгжилт
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн үйл ажиллагааг улс, салбар, салбар хоорондын болон бүс болон орон нутгийн хэмжээнд нэгтгэн зохион байгуулж, нэгдсэн арга зүй, удирдлага, зохион байгуулалтаар хангах	Тус яам нь тухайн үед Үндэсний хөгжлийн газар байсан бөгөөд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг ЗГХЭГ нэгтгэн боловсруулахаар тогтсон гэсэн тайлбар өгсөн. Үүнтэй холбоотойгоор тус яаманд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг төлөвлөхтэй холбоотой баримт материал байхгүй байсан болно.
Хөгжлийн бодлогын баримт бичгийн төслийг энэ хуульд заасан зарчим, шаардлагыг баримтлан боловсруулах	
Зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлох	
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулахад оролцох төрийн байгууллага болон эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, хувийн хэвшлийн төлөөллийг хангаж, их, дээд сургууль, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага, иргэний оролцоог хангах нөхцөлийг бүрдүүлэх	
Төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад нэгдсэн удирдлагаар хангах, арга зүйн зөвлөгөө өгөх	

Засгийн газар	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг боловсруулахад хууль тогтоомжид заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.
----------------------	---

1.14. ЗГ дараах чиг үүргийг⁵ хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд хэрэгжилт нь дараах байдалтай байна. Үүнд:

⁴ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4 дэх заалт

⁵ Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт

Чиг үүрэг	Чиг, үүргийн хэрэгжилт
Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Хөгжлийн зорилтот хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл , Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг боловсруулж хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх.	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг хуульд заасан шаардлагын дагуу боловсруулсан баримт материал ЗГХЭГ-т байхгүй байсан болно. Тус газраас “Алсын хараа – 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн боловсруулалттай холбоотой материал ирүүлсэн ба уг баримт бичгийн нэгдүгээр үе шатны 2021-2025 оны тооцоолол нь “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-тэй хамт боловсруулагдсан гэсэн тайлбар ирүүлсэн. Энэ материал, тайлбараас харахад тухайн чиг үүргээ хэрэгжүүлсэн гэж дүгнэх нөхцөл үүсэхгүй байна.
Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн уялдаа холбоо, нийцлийг хангаж, давхардал, хийдэл, зөрчлийг арилгах.	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг “Алсын хараа – 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцүүлэн боловсруулсан байна.


Дээрх нөхцөл байдлаас харахад хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг боловсруулахад оролцож буй байгууллагууд ажлын уялдаагүй, хариуцлагагүй, чиг үүргээ бүрэн хэрэгжүүлдэггүй байна. Энэ нь хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг хууль тогтоомжид заасан шаардлагад нийцээгүйгээс хэрэгжилт нь бүрэн хангагдах боломжгүй нөхцөлд хүргэж байна.

1.15. “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан 243 АХ-ээс 165 нь ТЕЗ-ийн саналд үндэслээгүй, 41 нь УИХ-ын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдсэн байна. Энэ 41 АХ-ний 15 нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаагүй байна. Энэ нь Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.12-т заасан зарчимтай нийцэхгүй байна. *41 АХ-ний дэлгэрэнгүйг хавсралт №1-ээс харна уу.*

Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр

1.16. “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал”-д⁶ улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээнд ТЕЗ-чид дараах үнэлгээг хийхээр тусгасан байна.

⁶ Үндэсний хөгжлийн газрын даргын (хуучин нэрээр) 2020 оны А.-56 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар баталсан.



1.17. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан ТАХ-нд дээрх үнэлгээг хийсэн эсэхийг авч үзвэл:

Хүснэгт 2. Төслийн ач холбогдлын үнэлгээ, хэрэгжих боломжийн үнэлгээг хийсэн байдал

№	Төрөл	Үнэлсэн	Үнэлээгүй
Төслийн ач холбогдлын үнэлгээ			
1	Хөтөлбөрт туссан бусад арга хэмжээтэй уялдсан байдал	93	57
2	Нийгмийн ач холбогдлыг тооцсон байдал	42	108
3	Эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг тооцсон байдал	42	108
4	Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөг тооцсон байдал	42	108
5	Бүс орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөөг тооцсон байдал	42	108
Хэрэгжих боломжийн үнэлгээ			
1	Хууль эрх зүйн орчныг үнэлсэн байдал	41	109
2	Дэд бүтцийн хүрэлцээг тооцсон байдал	42	108
3	Төсөл хэрэгжүүлэх бэлэн байдлыг үнэлсэн байдал	35	115
4	Төлөвлөлт, шийдлийн хувьд хэрэгжих боломжтой эсэхийг үнэлсэн байдал	36	114
5	Санхүү, эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой эсэхийг үнэлсэн байдал	36	114
6	Эрсдэлийн түвшнийг үнэлсэн байдал	30	120

Эх сурвалж: Аудиторын судалгааны нэгтгэл

1.18. ТЕЗ-чид ТАХ-нд дээрх үнэлгээг хийгээгүй нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Дүрслэл 1. Үнэлгээ хийгээгүй шалтгааны ангилал.



Эх сурвалж: Аудиторын судалгааны нэгтгэл

Дээрх үзүүлэлтээс харахад хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан ТАХ-нд ач холбогдлын болон хэрэгжих боломжийн үнэлгээг хийсэн нотлох баримт ТЕЗ нарт байхгүй байна.

Байгууллагуудын чиг үүргийн хэрэгжилт

1.19. Төсвийн тухай хуульд байгууллагуудын чиг үүргийг дараах байдлаар тусгасан боловч хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна.

Сангийн яам

- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төсөл нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Өрийн удирдлагын тухай хууль болон Стратегийн баримт бичигт заасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянан баталгаажуулах чиг үүрэгтэй ч энэ чиг үүргээ хэрэгжүүлээгүй байна.
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт багтсан төсөл, арга хэмжээний нийт өртөг, эхлэх болон дуусах хугацаа, төсвийн жилд зарцуулах хэмжээгээр тусгах гэж заасан чиг үүргийг хэрэгжүүлсэн байна.

ТЕЗ

- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгуулах төсөл, арга хэмжээний саналыг санал боловсруулах бүх шатанд олон нийтээр хэлэлцүүлсэн байх чиг үүрэгтэй ч нийт 150 ТАХ-ээс 123-г нь олон нийтээр хэлэлцүүлээгүй байна.
- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөлд орон нутгийн иргэдийн саналыг авсан байх чиг үүрэгтэй ч нийт 150 ТАХ-ээс 123-т нь орон нутгийн иргэдийн саналыг аваагүй байна.

Эдийн засаг, хөгжлийн яам

(Тухайн үеийн
Үндэсний хөгжлийн газар)

“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-ийг боловсруулахад хууль тогтоомжид заасан чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүй байна.

1.20. Төсвийн тухай хуульд ЭЗХЯ нь Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах ТАХ-нд дараах тооцоо, судалгаа хийхээр тусгасан байна. Үүнд:

ЭЗХЯ-ны чиг үүрэг	Чиг үүргийн хэрэгжилт
Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээний тэргүүлэх ач холбогдол, хэрэгжүүлэх дарааллыг хуулийн 28 дугаар зүйлийн 28.3-д заасан шаардлагыг харгалзан тогтоох	Тус яам нь тухайн үед Үндэсний хөгжлийн газар байсан бөгөөд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн төслийг ЗГХЭГ нэгтгэн боловсруулахаар тогтсон гэсэн тайлбар өгсөн.
Хуулийн 28.3.1-28.3.8, 28.3.12-т заасныг харгалзан улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах 30.0 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний төсөл, арга хэмжээнд техник, эдийн засгийн үндэслэлийн урьдчилсан судалгааг хийх	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д санал авахаар Үндэсний хөгжлийн газрын даргын 2020 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 01/1089, 01/1090 дугаартай албан бичгүүдийг төрийн захиргааны болон төв байгууллагууд, орон нутгийн захиргааны байгууллагуудад тус тус хүргүүлсэн боловч Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах, арга хэмжээний саналыг тусгайлан авч
Хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийх	

Шинээр болон үргэлжлэн хэрэгжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний саналыг бэлтгэх	эрэмбэлсэн, үнэлсэн, тооцоо судалгаа хийсэн эсэх нь нотлох баримтаар дэмжигдэхгүй байна
--	---

1.21. ЭЗХЯ “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал”-д заасны дагуу⁷ ТЕЗ-дын ирүүлсэн үнэлгээ, эрэмбийг харгалзан төслүүдэд **“Иж бүрэн үнэлгээ”** хийх хэдий ч уг чиг үүргээ хэрэгжүүлээгүй, ТЕЗ-аас Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт нийт хэдэн төсөл, арга хэмжээний санал ирж, түүнд боловсруулалт хийсэн талаарх нотлох баримт байхгүй байна.

1.22. ЭЗХЯ Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах ТАХ-нд хууль тогтоомжид заасан тооцоо, судалгаа, үнэлгээ хийгээгүй нь Төрийн байгууллагын залгамж чанар, тогтвортой байдалтай холбоотой байна. Энэ нь ЗГХЭГ болон ЭЗХЯ-аас аудитад ирүүлсэн тайлбар, албан бичгээр нотлогдож байна.

1.23. Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах ТАХ-нд хууль тогтоомжид заасан тооцоо, судалгаа, үнэлгээг бүрэн хийгээгүйгээс ТАХ-ний хэрэгжилтийг бодитой тооцох боломжгүй нөхцөлд хүргэсэн байна.

⁷ “Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал”-ын 4.2, 4.3 дахь заалт

БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ 67.7 ХУВЬ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨР 61.7 ХУВЬТАЙ ХЭРЭГЖСЭН БАЙНА


“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээг богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт тусган хэрэгжүүлэх үйл явц хангалтгүй байна

2.1. Дунд хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг хэрэгжүүлэх талаар Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд дараах байдлаар тусгасан байна. Үүнд:

- Хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13-т “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг **тухайн жилд хэрэгжүүлэх** төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичгийг,
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.3-т “Улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх”

2.2. Эдгээр заалтын дагуу “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон Тухайн жилийн төсвийн тухай хуульд хэрхэн тусган хэрэгжүүлснийг харуулбал:

Дүрслэл 2. МУХТЖҮЧ-ийн УХЖТ болон Төсвийн тухай хуулийн уялдаа



Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2021 онд Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө батлагдаагүй болно.

2.3. Дүрслэлээс нийт 243 арга хэмжээний 25.5 – 52.7 хувь нь Монгол Улсын хөгжлийн 2022, 2023, 2024, 2025 оны төлөвлөгөөнд туссан, 36.6 – 49.4 хувь нь Монгол Улсын 2021-2025 оны төсвийн тухай хуульд туссан байна.

Дээрх 243 арга хэмжээнээс 2022-2025 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийт **53** арга хэмжээ буюу **21.8** хувь нь огт тусаагүй байна.

2.4. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан нийт 150 төсөл, арга хэмжээний 19.3-30.0 хувь нь Монгол Улсын хөгжлийн 2022, 2023, 2024, 2025 оны төлөвлөгөөнд туссан бол 8.0-16.0 хувь нь Монгол Улсын 2021-2025 оны төсвийн тухай хуульд туссан байна.

Дүрслэл 3. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн УХЖТ болон Төсвийн тухай хуулийн уялдаа.




Эх сурвалж: Аудиторын тооцоолол

Дээрх 150 ТАХ-ээс 2022-2025 оны Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийт **64 ТАХ** буюу **42.6** хувь нь огт тусаагүй байна.

2.5. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан АХ Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд хэрхэн туссан, тэдгээр АХ нь тухайн жилийн Төсвийн тухай хууль хэрхэн тусаж байгаа зураглалыг харуулбал:

Дүрслэл 4. УХЖТ болон Төсвийн тухай хуулийн уялдаа.




Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.6. Дээрх зураглалаас харахад дунд хугацаанд төлөвлөсөн арга хэмжээнээс богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээ төсөвлөлтийн үйл явцад хасагдаж байна.

2.7. Энэ нь нэг талаар санхүүжилтийн эх үүсвэртэй холбоотой бөгөөд богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт улсын төсвөөс санхүүжихээр төлөвлөсөн арга хэмжээг тухайн жилийн Төсвийн тухай хуультай харьцуулахад дараах байдалтай байна.

Дүрслэл 5. УХЖТ, Төсвийн тухай хуулийн уялдаа




Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.8. Дээрх үзүүлэлтээс харахад УХЖТ-д туссан Улсын төсвөөр санхүүжих АХ нь тухайн жилийн Төсвийн тухай хуулийн 25.0-38.4 хувийг, санхүүжих мөнгөн дүн нь 20.6-66.4 хувийг эзэлж байгаа нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10.3-т “улсын төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Дүрслэл 2, 3, 4, 5-д тусгасан мэдээллээс харахад “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээг богино хугацааны хөгжлийн төлөвлөлтийн баримт бичигт бүрэн тусгаагүй байна. Энэ нь нэг талаар төлөвлөлт оновчтой бус нөгөө талаар үндсэн чиглэлд тусгасан арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй байх нөхцөлийг үүсгэсэн байна.

2.9. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээний гүйцэтгэл дараах байдалтай байна.

Дүрслэл 6. ТАХ-ний хэрэгжилтийн байдал, /бодлогоор/



Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.10. Дээрх үзүүлэлтээс харахад нийт арга хэмжээний 65.4 хувь нь бүрэн хэрэгжээгүй байна. Бүрэн хэрэгжээгүй шалтгааныг ангилан харуулбал:

Дүрслэл 7. Бүрэн хэрэгжээгүй ТАХ, /шалтгаанаар/




Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.11. Удирдлага, зохион байгуулалт, байгууллагын хамтын ажиллагаатай холбоотой болон шалгуур үзүүлэлт, хүрэх түвшнийг оновчтой тогтоогоогүй, санхүүжилт шийдвэрлэгдээгүй зэрэг шалтгаан нь төлөвлөсөн арга хэмжээ бүрэн хэрэгжихгүй байхад голлон нөлөөлсөн байна.

2.12. Мөн 45 АХ-г зарим ТЕЗ нар жил бүрийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тодорхой тусгаагүйгээс хэрэгжилт бүрэн хангагдахгүй байхад нөлөөлсөн байна.

2.13. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшнийг ҮСХ-оос аудитад ирүүлсэн мэдээллийг тоймлон харуулбал:

Дүрслэл 8. 2024 оны байдлаар хүрсэн түвшнийг тооцсон байдал



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

2.14. Дээрх байдлаас харахад хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээний тухайн оны хүрсэн түвшний талаарх албан ёсны мэдээллийн боловсруулалт хангалтгүй байгааг харуулж байна. Энэ нь хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан АХ зорилтот түвшиндээ хүрсэн эсэхийг нарийвчлан тооцох боломжгүй болгож байна.

2.15. Энэ мэдээллийг ТЕЗ, ЭЗХЯ болон ЗГХЭГ-аас тодруулахад: 95 шалгуур үзүүлэлтээс ТЕЗ нар 41, ЭЗХЯ 28, ЗГХЭГ 33 шалгуур үзүүлэлтийн 2024 онд хүрсэн түвшний мэдээллийг тус тус гаргаагүй байна.

Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан АХ-ний жил жилийн хүрсэн түвшний мэдээллийг тухай бүр гаргадаг байх тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай нь дээрх нөхцөл байдлаас харагдаж байна.

2.16. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 95 шалгуур үзүүлэлтийг ҮСХ-оос гаргасан “Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2024 оны урьдчилсан танилцуулга”-д танилцуулсан статистик мэдээлэлтэй харьцуулахад дараах мэдээллүүдийн хүрсэн түвшний үзүүлэлт гарсан байна.

Хүснэгт 3. Зарим арга хэмжээний суурь, хүрэх түвшин, үр дүнгийн харьцуулалт

Арга хэмжээ	Суурь түвшний үзүүлэлт	Хүрэх түвшний үзүүлэлт	2024 оны статистик үзүүлэлт
Нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүний хэмжээ (ам.доллар)	4009	6520	6738.5
Экспорт (сая ам.доллар)	7011.8	14020	15783.4
Хүлээн авах гадаад жуулчдын тоо (сая хүн)	0.6	1	0.7
Шинэ бүтээл, патентын мэдүүлэг, дотоодын мэдүүлэг	82	150+	186
Цэцэрлэгийн бүлгийн багшид ногдох хүүхдийн тоо	34.1	25	27
Улаанбаатар хотын агаар дахь PM 2.5 тоосонцрын жилийн дундаж агууламж (мкг/м3)	64	40	42
Улаанбаатар хотын агаар дахь PM10 тоосонцрын жилийн дундаж агууламж (мкг/м3)	141	88	84

Эх сурвалж: Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдлын 2024 оны урьдчилсан танилцуулга

2.17. Дээрх мэдээллээс харахад зарим АХ 2024 оны байдлаар зорилтот түвшинд хүрсэн байна.

Үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгасан арга хэмжээний гүйцэтгэлийг бодитой, үнэн зөв тайлагнаж, үнэлээгүй байна

Үнэлгээ өгсөн байгууллагууд болон аудитын үнэлгээний зөрүү

Үнэлгээ өгсөн байгууллагууд үндсэн чиглэлийн зөвхөн 2024 оны гүйцэтгэлд үнэлгээ өгсөн ба аудитын үнэлгээ нь хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнд өгсөн болно.

Үндсэн чиглэл

2.18. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д туссан бодлого, зорилго, ТАХ-ний гүйцэтгэлийг үнэлсэн үнэлгээг холбогдох байгууллагаар харьцуулан харуулбал:

Тодорхойлсон бодлого, зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн АХ-ний дундаж үнэлгээ:

Хүснэгт 4. Үндсэн чиглэлд туссан бодлого, зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн АХ-ний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/

№	Тодорхойлсон бодлого, зорилго	АХ-ний тоо	Хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээ	ЭЗХЯ-ны үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ	Аудитаар үнэлсэн үнэлгээ
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	94.4	82.5	51.9	60.6
2	Хүний хөгжил	49	88.2	80.4	65.9	75.1
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	27	93.7	82.2	66.3	71.1
4	Эдийн засаг	35	86.4	78.3	72.6	70.9
5	Засаглал	25	94.8	80.0	55.2	68.8

6	Ногоон хөгжил	18	81.7	71.1	63.9	55.6
7	Амар тайван, аюулгүй нийгэм	23	91.7	84.3	81.7	80.0
8	Бүс, орон нутгийн хөгжил	29	74.5	69.0	61.7	51.1
9	Улаанбаатар ба дагуул хот	21	96.0	66.2	57.1	65.2
Нийт /дундаж/		243	88.4	77.5	66.7	67.7

Эх сурвалж: ТЕЗ, ЭЗХЯ, ЗГХЭГ, Аудитын үнэлгээ

2.19. Дээрх үзүүлэлтээс харахад “Үндэсний нэгдмэл үнэт зүйл”, “Ногоон хөгжил”, “Бүс, орон нутгийн хөгжил”-ийн хүрээнд хэрэгжүүлсэн АХ-ний гүйцэтгэл хангалтгүй байна.

Тодорхойлсон зорилго, зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн АХ-ний дундаж үнэлгээ:

Хүснэгт 5. Үндсэн чиглэлд туссан зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн АХ-ний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/

№	Зорилго, зорилт	АХ- ний тоо	Хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээ	ЭЗХЯ- ны үнэлгээ	ЗГХЭГ- ын үнэлгээ	Аудитаар үнэлсэн үнэлгээ
Үндэсний нэгдмэл үнэт зүйл		16	94.4	82.5	51.9	60.6
1	Үндэсний нэгдмэл бахархлыг сэргээж, хамтын үнэт зүйлс, тэмүүлэл, эх оронч үзэл, эв нэгдлийг бэхжүүлнэ	5	90.0	78.0	70	62.0
2	Нүүдлийн өв соёлоо хадгалж, ёс заншил, уламжлалаа түгээн дэлгэрүүлнэ.	4	97.5	80.0	42.5	70.0
3	Үндэсний Монгол хэл, бичгээ чанартай эзэмшиж, хэрэглэж хэвшинэ.	2	100	90.0	60	60.0
4	Үнэт зүйлийн болон олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааг салбар бүрээр хийж, нийтийн хүртээл болгоно.	2	100	90.0	60	80.0
5	Олон улс дахь Монгол үндэсний үнэт зүйлсийн дархлааг бэхжүүлж, монгол соёлын хүрээг тэлнэ.	3	90	83.3	23.3	33.3
Хүний хөгжил		49	88.2	80.4	65.9	75.1
1	Хүн бүрд чанартай боловсрол эзэмших тэгш боломж бүрдүүлж, тэгш хамруулах тогтолцоог бэхжүүлнэ.	12	100	88.3	73.3	90.0
2	Эрүүл мэндийн чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцооны шинэчлэл хийнэ.	8	67.5	67.5	57.5	65.0
3	Гэр бүлд ээлтэй бодлого хэрэгжүүлж, хүн амын тогтвортой өсөлт, хүний хөгжлийг дэмжинэ.	5	98.0	92.0	70	96.0
4	Шинжлэх ухаан, технологийг улс орны тогтвортой хөгжлийн үндсэн хүчин зүйлсийн нэг болгон хөгжүүлж, үр ашигтай үндэсний инновацын тогтолцоог бүрдүүлнэ.	9	95.6	94.4	73.3	78.9
5	Эрүүл баталгаат орчныг бий болгоно.	6	83.3	56.7	45.0	46.7
6	Хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрт байдлыг хангах, хэрэгцээнд суурилсан хөдөлмөрийн хөлс, урамшууллын оновчтой тогтолцоог бэхжүүлнэ.	5	84.0	72.0	72.0	70.0

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

7	Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, дэмжинэ.	4	77.5	82.5	62.5	65.0
Амьдралын чанар ба дундаж давхарга		27	93.7	82.2	66.3	71.1
1	Нийгмийн хамгааллын тогтолцоог шинэчилнэ.	5	96.0	82.0	88.0	88.0
2	Өрх, гэр бүлийн худалдан авах чадварт нийцсэн өртөг бүхий сууцаар хангах тогтолцоог бүрдүүлнэ.	4	100	70.0	27.5	65.0
3	Хөдөлмөр эрхлэлт, бүтээлч санаачилга, хандлага болон ур чадварыг хөгжүүлэх, аж ахуй эрхлэлтийг дэмжсэн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.	5	94.0	86.0	70.0	70.0
4	Дундаж давхаргыг тэлэхэд чиглэсэн санхүүгийн үйлчилгээг бэхжүүлнэ.	2	95.0	80.0	80.0	70.0
5	Биеийн тамир, спортын чанар, хүртээмжтэй, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.	5	98.0	84.0	54.0	64.0
6	Монгол Улсын газрын харилцаа, геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөлт, хэрэгжилтийн үр нөлөө, хүртээмжийг дээшлүүлж, хүн амын эрүүл, аюулгүй, ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.	6	83.3	86.7	76.7	68.3
Эдийн засаг		35	86.4	78.3	72.6	70.9
1	Засгийн газрын хугацаа тулсан гадаад өр төлбөрийг макро эдийн засгийн тогтвортой байдлыг алдагдуулахгүйгээр шийдвэрлэж, үр ашгийг дээшлүүлж, макро эдийн засгийн тэнцвэрт байдлыг хангаж, эрсдэл даах чадварыг нэмэгдүүлнэ.	7	93.6	90.0	78.6	85.7
2	Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	16	75.2	66.3	65.0	65.6
3	Эдийн засгийг тэтгэсэн, уян хатан, цахим технологид суурилсан олон талт санхүүгийн үйлчилгээг хөгжүүлнэ.	5	98.8	96.0	74.0	66.0
4	Хөрш орнуудтай хамтран эдийн засгийн коридорыг хөгжүүлэх, Евразийн эдийн засгийн холбоо, Бүгд Найрамдах Солонгос Улстай чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулах эсэх талаар урьдчилсан судалгааг эхлүүлнэ.	4	98.8	77.5	82.5	65.0
5	Бичил, жижиг, дунд үйлдвэрлэлийг инновацад тулгуурлан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлнэ.	2	95.0	80.0	80.0	70.0

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

6	Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ.	1	100	100	90.0	100
Засаглал		25	94.8	80	55.2	68.8
1	Эрх мэдлийн хуваарилалт, тэнцвэртэй байдал, түүнд тавих хяналтыг оновчтой болгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, тогтвортой, хяналттай засаглалыг төлөвшүүлнэ.	4	96.3	82.5	60.0	50.0
2	Төрийн захиргааны байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, чиг үүрэг, эрх мэдлийн зааг, ялгааг оновчтой тодорхойлж, оролцоог зохистой хангасан, иргэдээ сонсдог, хувийн хэвшилтэйгээ хамтарч ажилладаг тогтолцоог бий болгоно.	3	96.7	86.7	80.0	86.7
3	Мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, үр дүнтэй цахим засаглалын бодлогын болон хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, төлөвшүүлнэ.	4	97.5	90.0	70.0	92.5
4	Чадахуйн зарчимд суурилсан мэргэшсэн, тогтвортой төрийн албыг бэхжүүлж, төрийн үйлчилгээний үр дүн, үр нөлөөг дээшлүүлнэ.	7	88.6	80.0	44.3	68.6
5	Хүний эрхийг хангах үндэсний тогтолцоог бэхжүүлэх, хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хүний эрхийг хангахад чиглэсэн олон талт түншлэлийг хөгжүүлнэ.	4	96.7	52.5	30.0	50.0
6	Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс сэргийлэх хууль, эрх зүйн болон бодлогын орчин, шударга ёсыг эрхэмлэсэн бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ.	3	100	93.3	63.3	70.0
Ногоон хөгжил		18	81.7	71.1	63.9	55.6
1	Цэнгэг усны нөөц, урсац бүрэлдэх эх зэрэг онцлог экосистем бүхий газар нутгийг судалж, улсын тусгай хамгаалалттай газар нутгийг өргөжүүлэн эдийн засгийн үр өгөөжийг үнэлнэ.	2	60.0	60.0	60.0	50.0
2	Байгаль орчныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах, шинжлэх ухааны үндэслэлтэй бодлого хэрэгжүүлж, доройтсон орчныг нөхөн сэргээж нөөцийн хомсдолыг бууруулах, ашиглалтын нөөц бий болгоно.	5	92.0	88.0	76.0	62.0
3	Усны хуримтлал, ус хангамжийг нэмэгдүүлж, усны нөөцийг бохирдол, хомсдолоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлнэ.	4	80.0	70.0	70.0	65.0

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

4	Ногоон хөгжлийн бодлогыг хэрэгжүүлж, байгальд ээлтэй, нөөцийн хэмнэлттэй, үр ашигтай цэвэр технологи нэвтрүүлэн, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох үндэсний чадавхыг бүрдүүлнэ.	7	81.4	62.9	52.9	47.1
Амар тайван, аюулгүй нийгэм		23	91.7	84.3	81.7	80.0
1	Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоог бэхжүүлж, үндэсний язгуур ашиг сонирхолд тулгуурласан мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлнэ.	4	70.0	70.0	70.0	70.0
2	Хилийн аюулгүй байдлыг хангах нэгдмэл тогтолцоог бүрдүүлж, бүсчилсэн хил хамгаалалтыг хөгжүүлэн холбоо, зэвсэглэл, техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, дэд бүтцийг хөгжүүлнэ.	4	100	92.5	87.5	87.5
3	Уламжлалт бус аюулын хүчин зүйлсийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чадавхыг бэхжүүлж, төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	6	88.3	76.7	76.7	73.3
4	Хууль сахиулах салбарын хууль, эрх зүйн орчин, материаллаг баазыг бэхжүүлнэ.	7	100	92.9	88.6	84.3
5	Кибер аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлж, технологид суурилсан инновац, интеграцыг хөгжүүлж, эрсдэлийн менежментийн үндэсний чадавхыг бэхжүүлнэ.	2	100	90.0	85.0	90.0
Бүс, орон нутгийн хөгжил		29	74.5	69.0	61.7	51.1
1	Эдийн засгийн тэргүүлэх бүс нутаг, салбаруудыг дэд бүтцээр холбоно.	11	82.7	79.1	67.3	48.0
2	Үндэсний онцлог бүхий, байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэдэд түшиглэсэн тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	3	56.7	46.7	46.7	21.7
3	Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц ашиглалт, эдийн засгийн эргэлтийг эрчимжүүлж, тооноос чанар, бүтээмжид шилжүүлнэ.	15	72.0	66.0	60.7	59.3
Улаанбаатар ба дагуул хот		21	96.0	66.2	57.1	65.2
1	Нийгмийн дэд бүтцийн чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлнэ.	3	88.3	76.7	70.0	73.3
2	Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангаж, нөхөн сэргээх, хариуцлагатай, хэмнэлттэй хэрэглээг бий болгоно.	4	92.5	60.0	60.0	62.5

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

3	Хотын төвлөрлийг задалж дэд бүтцийн хүртээмжийг нэмэгдүүлэх, ухаалаг технологийн шинэчлэл хийнэ.	5	100	60.0	50.0	54.0
4	Хууль, эрх зүйн шинэчлэл хийж, хотын засаглал, эдийн засаг, нийгмийн таатай орчныг бүрдүүлнэ.	3	100	80.0	73.3	80.0
5	Хөрөнгө оруулалтын шинэ боломж бүрдүүлж, үйлдвэрлэлийн бүс нутгийг тэлнэ.	6	96.7	63.3	46.7	65.0
Нийт /дундаж/		243	88.5	77.5	66.7	67.7

Эх сурвалж: ТЕЗ, ЭЗХЯ, ЗГХЭГ, Аудитын үнэлгээ

2.20. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хэрэгжүүлэгч байгууллагуудын АХ-ний үнэлгээг харьцуулан харуулав.

Хүснэгт 6. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээ /хувь/

№	Хэрэгжүүлэгч байгууллага	Хэрэгжүүлэгч байгууллагын үнэлгээ	ЭЗХЯ-ны үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлгээ		Аудитаар үнэлсэн үнэлгээ
				Үндсэн	Хамтран	
1	АТГ	-	100	50.0	-	50.0
2	АҮЭБЯ	87.5	30.0	50.0	86.7	50.0
3	БОУАӨЯ	75.5	74.7	64.3	55.0	54.0
4	БХЯ	70.0	70.0	70.0	-	70.0
5	БЯ	100	88.5	74.6	70.0	86.8
6	ГБХНХЯ	95.0	82.9	77.5	82.5	87.6
7	ГЗБГЗЗЕГ	80.0	84.0	72.0	-	62.0
8	ГХЯ	95.0	63.3	70.0	100.0	60.0
9	ЗГХЭГ	85.8	80.0	55.7	30.0	63.3
10	ЗТЯ	88.2	77.2	75.5	62.0	50.1
11	НЗДТГ	96.3	64.4	67.5	52.7	74.0
12	МБ	-	-	-	30.0	-
13	ОБЕГ	53.3	50.0	60.0	30.0	50.0
14	ССАЖЗЯ	91.1	78.8	54.3	50.0	56.1
15	СХЗГ	100	90.0	80.0	-	90.0
16	СЯ	98.1	90.0	76.0	68.0	84.6
17	ТАЗ	100	74.0	42.0	90.0	75.0
18	ТЕГ	-	-	-	-	100
19	ТХААГ	70.0	60.0	70.0	50.0	50.0
20	ХББОСЯ	95.8	52.5	30.0	48.5	54.2
21	ХЗДХЯ	100	91.0	86.8	62.5	80.0
22	ХХААХҮЯ	76.0	67.3	63.6	56.7	65.2
23	ХЭҮК	100.0	70.0	25.0	-	30.0
24	ЦХИХХЯ	98.0	90.0	70.0	90.0	93.0
25	ШЕЗ	-	0.0	0.0	-	70.0
26	ШСАА	100	100.0	100.0	-	100
27	ЭЗХЯ	94.0	93.1	76.7	75.7	80.0
28	ЭМЯ	62.3	70.0	55.5	40.0	59.2
29	ЭХЯ	62.1	64.0	56.0	60.0	52.9

Эх сурвалж: ТЕЗ, ЭЗХЯ, ЗГХЭГ, Аудитын үнэлгээ

2.21. Дээрх үзүүлэлтээс харахад үнэлгээ өгсөн байгууллагууд зарим хэрэгжүүлэгч байгууллагуудын хэрэгжүүлсэн АХ-г үнэлээгүй байна. Энэ нь үндсэн чиглэлд тусгасан АХ-г бүрэн үнэлээгүйг харуулж байна.

2.22. Холбогдох байгууллагуудын “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг үнэлсэн үнэлгээнээс харахад үнэлгээг бодит гүйцэтгэл, нотлох баримтад суурилсан, цогц байдлаар хийгээгүй байна.

Нөгөө талаар үнэлгээ хийсэн байгууллагууд үндсэн чиглэлийг хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр үнэлгээ хийгээгүй ба тухайн жилийн дүнгээр үнэлгээ хийсэн байна. Энэ нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.4-т “Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь өөрийн зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг хөтөлбөр хэрэгжсэн хугацааны **нэгдсэн дүнгээр**” гүйцэтгэлийн тайланд тусгана гэж заасантай нийцэхгүй байна.

Энэ нөхцөл байдалтай холбоотойгоор үнэлгээ хийсэн байгууллагуудын “**Үнэлгээ**” болон ТАБ-ын “**Үнэлгээ**”-ний хооронд зөрүү үүссэн болно.

ТАБ “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн үнэлгээг хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр хийсэн.

2.23. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тодорхойлсон бодлого, зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн АХ-ний үр дүнгийн үзүүлэлт дараах байдалтай байна.

Хүснэгт 7. Бодлого, зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн АХ-ний хэрэгжилтийн үр дүнгийн үзүүлэлт

Бодлого, зорилгын нэр	АХ-ний тоо	Үр дүнгийн үзүүлэлт				Аудитын үнэлгээ (хувиар)
		Үр дүнтэй (100)	Тодорхой үр дүнд хүрсэн (99-70)	Эрчимжүүлэх шаардлагатай (69-30)	Үр дүнгүй (29-0)	
Үндэсний нэгдмэл үнэт зүйл	16	0	10	5	1	60.6
Хүний хөгжил	49	15	21	13	0	75.1
Амьдралын чанар ба дундаж давхарга	27	5	15	7	0	71.1
Эдийн засаг	35	3	21	10	1	70.9
Засаглал	25	5	12	8	0	68.8
Ногоон хөгжил	18	0	7	11	0	55.6
Амар тайван, аюулгүй нийгэм	23	3	18	2	0	80.0
Бүс, орон нутгийн хөгжил	29	0	12	14	3	51.1
Улаанбаатар ба дагуул хот	21	5	6	9	1	65.2
Нийт	243	36	123	78	6	67.7

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.24. Нийт 243 ТАХ-ээс **14.8** хувь нь “Үр дүнтэй”, **50.2** хувь нь “Тодорхой үр дүнд хүрсэн”, **32.5** хувь нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, **2.5** хувь нь “Үр дүнгүй” байна. *Дэлгэрэнгүйг Хавсралт №2-оос харна уу.*

“Тодорхой үр дүнд хүрсэн” **123** АХ-нд гүйцэтгэл нь **70-99** хувьтай, “Эрчимжүүлэх шаардлагатай” **78** АХ-нд гүйцэтгэл нь **30-69** хувьтай АХ багтсан бөгөөд нийт АХ-ний гүйцэтгэлийн дундаж хувь “**67.7**”-д голлон нөлөөлсөн болно.


21.7 их наяд төгрөгийн хөрөнгө оруулалт

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан ТАХ-нд нийт 21.7 их наяд төгрөг зарцуулсан ч улс хэрхэн хөгжиж, ямар эерэг өөрчлөлт бий болсныг тооцоогүй байна.

Хөрөнгө оруулалтын хөтөлбөр

2.25. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан ТАХ-ний гүйцэтгэлийг авч үзвэл:

Дүрслэл 9. ТАХ-ний гүйцэтгэл, /бодлогоор/



2.26. Дээрх үзүүлэлтээс харахад нийт арга хэмжээний 53.3 хувь нь зорилтот түвшинд хүрээгүй байна. *Дэлгэрэнгүйг Хавсралт №3-аас харна уу.*

2.27. Зорилтот түвшинд хүрээгүй 80 ТАХ-ний шалтгааныг ангилан харуулбал дараах байдалтай байна. Дүрслэл 10. Зорилтод түвшинд хүрээгүй ТАХ /шалтгаанаар/



2.28. Дүрслэлээс харахад ТАХ зорилтод түвшинд хүрээгүйд удирдлага, зохион байгуулалт, санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдээгүй нь голлон нөлөөлсөн байна.

Тодорхойлсон бодлого, зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний дундаж үнэлгээ:

2.29. Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан ТАХ-ний гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч байгууллага болон ЗГХЭГ бүрэн үнэлээгүйгээс 9 зорилтын хүрээнд хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ТАХ-ний дунджийг бодитой харьцуулах боломж

хязгаарлагдаж байна. Энэ нь үнэлгээ өгсөн байгууллагууд үндсэн чиглэлд туссан АХ-г үнэлэхэд чиглэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан бодлого, зорилгын хүрээнд хэрэгжүүлсэн ТАХ-ний хэрэгжилтийн үнэлгээ /хувь/, үнэлсэн арга хэмжээний тоо

№	Тодорхойлсон бодлого, зорилго	ТАХ-ний тоо	Хэрэгжүүлэгч байгууллагын үнэлсэн ТАХ-ний тоо	ЭЗХЯ-ны үнэлгээ	ЗГХЭГ-ын үнэлсэн ТАХ-ний тоо	Аудитаар үнэлсэн үнэлгээ
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	6	6	75.0	6	75.0
2	Хүний хөгжил	19	9	60.5	18	61.1
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	14	5	63.6	14	60.7
4	Эдийн засаг	56	23	56.5	54	56.7
5	Засаглал	9	8	72.8	7	83.7
6	Ногоон хөгжил	6	0	65.8	6	60.0
7	Амар тайван, аюулгүй нийгэм	11	9	68.2	11	72.7
8	Бүс, орон нутгийн хөгжил	18	9	62.8	18	63.3
9	Улаанбаатар ба дагуул хот	11	0	33.6	7	50.0
Нийт /дундаж/		150		72.6		61.7

Эх сурвалж: Аудиторын үнэлгээ

2.30. Дээрх үзүүлэлтээс харахад “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Эдийн засаг”, “Улаанбаатар ба дагуул хот”-ын хүрээнд тодорхойлсон ТАХ-ний хэрэгжилт хангалтгүй байна.

2.31. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан ТАХ-ний санхүүжилтийн гүйцэтгэлийг харуулбал:

Хүснэгт 9. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан ТАХ-ний санхүүжилтийн гүйцэтгэл /тэрбум төгрөг/

№	Санхүүжилтийн эх үүсвэр	Батлагдсан санхүүжилт	Санхүүжилтийн гүйцэтгэл	Гүйцэтгэл /хувь/
1	Гадаад зээл, тусламж	14,085.1	7,224.6	51.3
2	Шууд хөрөнгө оруулалт	12,313.9	9,708.0	78.8
3	Хөгжлийн банкны санхүүжилт	296.0	436.3	147.4
4	Концесс, төр хувийн хэвшлийн түншлэл	6,270.4	995.8	15.9
5	Эх үүсвэр шийдвэрлэгдээгүй	2,974.8	-	-
6	Нийслэлийн төсөв	2.6	77.3	29.5 (дахин их)
7	Улсын төсөв	3,670.1	2,041.7	55.6
Нийт		39,612.9	20,483.4	51.7

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.32. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан ТАХ нь “Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн” гэж батлагдсан хэдий ч эдгээр ТАХ дотор “Эх үүсвэр шийдвэрлэгдээгүй” гэсэн нийт 2,974.8 тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 9 ТАХ батлагдсанаас 3 ТАХ-г Нийслэлийн төсвөөс санхүүжүүлж 28.7 тэрбум төгрөг зарцуулсан байна.

2.33. Санхүүжилтийн гүйцэтгэлээс харахад Хөгжлийн банк, Нийслэлийн төсвөөс бусад эх үүсвэрийн санхүүжилтийг хангалтгүй буюу бүрэн шийдвэрлээгүй байна. Концесс, төр хувийн түншлэл 15.9 хувь, Гадаадын зээл тусламж 51.3 хувь, Улсын төсөв 55.6 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь эдгээр эх үүсвэрийн санхүүжилтийг бодитой төлөвлөөгүйг илтгэж байна.

2.34. Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт туссан ТАХ-нд нийт 20,483.4 тэрбум төгрөг зарцуулсан байна. Энэ нь төлөвлөсөн санхүүжилтийн 51.7 хувийг эзэлж байна.

ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ТАХ

2.35. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай нийт 98 ТАХ-ний гүйцэтгэлийг хэрэгжүүлэгч байгууллага болон хэрэгжээгүй шалтгаанаар харуулбал.

Хүснэгт 10. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах шаардлагатай ТАХ-ний гүйцэтгэл

№	Хэрэгжүүлэгч байгууллага	ТАХ-ний тоо		
		Боловсруулсан	Боловсруулаагүй	Нийт
1	АҮЭБЯ		1	1
2	БОУАӨЯ		2	2
3	БЯ	1	2	3
4	ГБХНХЯ	1	2	3
5	ЗТЯ	16	14	30
6	ССАЖЗЯ	1		1
7	ССАЖЯ	1	6	7
8	ХББОСЯ	11	3	14
9	ХХААХҮЯ		3	3
10	ЦХИХХЯ		3	3
11	ЭЗХЯ		2	2
12	ЭМЯ	2	2	4
13	ЭХЯ	22	3	25
Нийт		55	43	98

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

Дүрслэл 11. ТЭЗҮ, зураг төсөл боловсруулаагүй байдал /шалтгаанаар/



2.36. Дээрх гүйцэтгэлээс харахад нийт 98 ТАХ-ээс 55 нь хэрэгжиж, 43 нь дүрслэлд харуулсан 6 шалтгааны улмаас бүрэн хэрэгжээгүй байна. Хэрэгжээгүй шалтгаанаас хамгийн их хувийг нотлох баримтгүй 18 ТАХ эзэлж байгаа нь хариуцсан яамдын үйл ажиллагаатай холбоотой байна.

2.37. Дээрх ТАХ-нүүдээс 2021-2025 оны Төсвийн тухай хуульд нийт 15 ТАХ-г 425.5 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна.

Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх ТАХ

2.38. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай нийт 88 ТАХ-ний гүйцэтгэлийг тодорхойлсон бодлого, зорилгын хүрээнд харуулбал:

Хүснэгт 11. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай ТАХ-ний гүйцэтгэл /тэрбум төгрөг/

№	Тодорхойлсон бодлого, зорилго	Батлагдсан төсөв өртөг	Шийдвэрлэсэн ТАХ-ний			Шийдвэрлээгүй ТАХ-ний тоо	ТАХ-ний ажлын гүйцэтгэл (хувь)
			төсөвт өртөг	гүйцэтгэл ийн хувь	тоо		
1	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	279.5	41.0	14.6	2	2	75.1
2	Хүний хөгжил	1,193.0	439.9	36.8	5	4	43.1
3	Амьдралын чанар ба дундаж давхарга	373.8	5.0	1.3	2	3	39.0
4	Эдийн засаг	4,590.7	724.9	15.8	5	11	10.9
5	Засаглал	70.5	-	-		1	
6	Ногоон хөгжил	950.1	-	-		6	
7	Амар тайван, аюулгүй нийгэм	354.0	-	-		6	-
8	Бүс, орон нутгийн хөгжил	9,067.1	1,807.6	19.9	27	9	32.4
9	Улаанбаатар ба дагуул хот	1,730.5	861.4	49.8	4	1	70.0
Нийт		18,609.1	3,879.9	20.8	45	43	38.6

Эх сурвалж: Аудиторын тооцоолол

2.39. Санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх шаардлагатай 18.6 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 88 ТАХ-ний 51.1 хувь буюу 45 ТАХ-нд 3.8 их наяд төгрөг зарцуулсан нь нийт төсөвт өртгийн **20.8** хувийг шийдвэрлэсэн байна.

2.40. Шийдвэрлэсэн 11.6 их наяд төгрөгийн төсөвт өртөгтэй 45 ТАХ-ээс 7 ТАХ-ний санхүүжилтийг 100 хувь, үлдсэн 38 ТАХ-ний санхүүжилтийг бүрэн шийдвэрлээгүйгээс ажлын гүйцэтгэл **38.6** хувьтай гарахад нөлөөлсөн байна.

2.41. Дээрх ТАХ-ний санхүүжилтийг шийдвэрлэсэн хугацааг авч үзвэл 2019-2025 онд 16 ТАХ-ний санхүүжилтийг хуваан шийдвэрлэсэн бол 2021, 2022, 2023, 2024, 2025 он тус бүрд 29 ТАХ-ний санхүүжилтийг шийдвэрлэсэн байна. Энэ нь ТАХ-ний санхүүжилтийг бага дүнгээр удаашруулж шийдвэрлэснийг харуулж байна.


2.42. Санхүүжилтийг шийдвэрлэхэд хяналт тавих, хэрэгжүүлэх үүрэгтэй ЭЗХЯ, Сангийн яам болон ТАХ-г хэрэгжүүлэгч байгууллагын мэдээлэл өөр хоорондоо зөрүүтэй байгаа нь төрийн байгууллагын харилцан уялдаагүй, хуульд заасан чиг үүргийг бүрэн хэрэгжүүлээгүй гэж дүгнэхэд хүргэж байна.

2.43. Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэх шаардлагатай нийт 18,609.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 88 ТАХ-ээс 2021-2025 оны Төсвийн тухай хуульд нийт 22 ТАХ-г 683.0 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнээс харахад улсын төсвөөс 2021-2025 онд шаардлагатай санхүүжилтийн **3.6** хувийг шийдвэрлэсэн байна.

**20.5 их наяд
төгрөгийн
хөрөнгө оруулалт**

“Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”-т тусгасан ТАХ-нд нийт 20.5 их наяд төгрөг зарцуулсан ч улс хэрхэн хөгжиж, ямар эерэг өөрчлөлт бий болсныг тооцоогүй байна.

2.44. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээ төлөвлөсөн хугацаанд хүрэх түвшинд хүрч, хэрхэн нөлөө үзүүлж байгааг авч үзвэл:



Холбогдох байгууллагууд “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт тус бүрээр тооцож, үнэлээгүй байна.

2.45. Энэ нь Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.3⁸ дахь заалттай нийцэхгүй байна. Дээрх үнэлгээг хийгээгүй нь урт, дунд хугацаанд тодорхойлсон зорилго, зорилт хугацаандаа хэрэгжих эсэх, өөрчлөлт оруулах шаардлагатай зорилт, арга хэмжээ байгаа эсэхийг тодорхойлох боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

Дээрх нөхцөл байдлаас харахад хэрэгжүүлэгч байгууллагууд “Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан зорилт, арга хэмжээ оновчтой эсэх, нийгэм, эдийн засагт эерэг өөрчлөлт бий болгох эсэхийг нь чухалчлахгүйгээр батлагдсан тул хэрэгжүүлнэ” гэсэн хандлагатай байна.

2.46. “Алсын хараа – 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын 2025 онд тодорхойлсон хүрэх үр дүнгийн үзүүлэлтийг “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тодорхойлсон хүрэх үр дүнгийн үзүүлэлтэд бүрэн тусгасан бөгөөд 2024 оны байдлаар 3 АХ-ны шалгуур үзүүлэлт хангагдаагүй байна.

- *Олон улсын зэрэглэлтэй болох нисэх буудлын тоо*
- *Шинээр баригдах улсын чанартай авто замын урт*
- *100,000 амьд төрөлтөд эхийн эндэгдлийн түвшин*

2.47. Монгол Улсын ЗГ-ын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 10-т Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг үнэлэх, тайлан илгээх, хүлээн авах, мэдээллийн урсгалыг удирдах, хянах, хадгалах, ашиглах, түгээхэд Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санг ашиглан мэдээллийг тогтоосон хугацаанд байршуулахаар заасан байна.

2.48. Журмын 7.5-д “Энэ журмын 3.2.1-д заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн тайланг мөн журмын 2-3 дугаар хавсралтын дагуу гаргаж, журмын 1 дүгээр хавсралтад заасан хугацаанд холбогдох

⁸ Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгасан зорилго, зорилт, хүрэх үр дүн нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн^[6] 6.2, 6.5-д заасан урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг зорилт тус бүрээр

байгууллагад хүргүүлнэ.” гэж заасныг дараах байгууллагууд хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:



Хяналт шинжилгээ, үнэлгээний мэдээллийн нээлттэй цахим сан

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар-16 хоног
Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам-7 хоног
Зам, тээврийн яам-2 хоног
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэлийн яам-5 хоног
Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны яам-2 хоног хэтрүүлж байршуулсан байна.

2.49. Үндсэн чиглэл, хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байдлыг авч үзвэл:



Үндсэн чиглэл		Хөрөнгө оруулалтын хөтөлбөр	
✓	84	✓	65
✗	43	✗	29
!	116	!	56

2.50. Дээрх үзүүлэлтээс харахад “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл-ийн хэрэгжилтийн талаар мэдээллийг шилэн дансанд бүрэн байршуулдаггүй байна.

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн хэрэгжилтийг нэгдсэн дүнгээр хуулийн хугацаанд тайлагнаагүй асуудалд тайлбар ирүүлэх талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт албан бичиг хүргүүлсэн бөгөөд тус газраас 2025.02.28-ны өдрийн албан бичгээр үндсэн чиглэлийн хэрэгжилтийг 2021-2024 оны байдлаар гарган ирүүлсэн болно. Энэ нь аудитын тайлангийн төсөл эцэслэн холбогдох байгууллагаас санал авахаар хүргүүлсний дараах үйл явц тул ирүүлсэн баримт материалд аудит хийх боломжгүй байсан болно.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” **67.7** хувьтай хэрэгжсэн бөгөөд нийт төсөл, арга хэмжээний **14.8** хувь нь “Үр дүнтэй”, **50.2** хувь нь “Тодорхой үр дүнд хүрсэн”, **32.5** хувь нь “Эрчимжүүлэх шаардлагатай”, **2.5** хувь нь “Үр дүнгүй” байна.
2. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийг хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу иж бүрэн, судалгаа тооцоотой боловсруулаагүйгээс төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй, гүйцэтгэлийг бодитой үнэлэхэд хүндрэл учруулж, нийгэм, эдийн засаг, байгаль орчны тогтвортой хөгжилд үзүүлэх үр нөлөөг бууруулж байна.
3. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тусгасан арга хэмжээг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, тухайн жилийн Төсвийн тухай хуульд тусган хэрэгжүүлэх үйл явц болон төлөвлөсөн санхүүжилтийн эх үүсвэрийн шийдвэрлэлт хангалтгүй байгаа нь хууль эрх зүйн уялдаагүй байдал, зохицуулалт дутагдалтай, оролцогч байгууллагуудын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлээгүйтэй холбоотой байна.
4. Хөгжлийн бодлогын баримт бичигт тусгасан арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй гүйцэтгээгүйд тооцох хариуцлагын талаарх хууль, эрх зүйн зохицуулалт хэт ерөнхий, нарийвчилсан шалгуургүйгээс хэрэгжүүлэгч байгууллагын албан тушаалтнууд хариуцлага хүлээхгүй байх нөхцөл бүрдсэн байна.
5. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” нь өөрийн зорилтот түвшинд хүрч, шалгуур, үзүүлэлтийг хангасан эсэхийг хэрэгжүүлэгч байгууллагууд, Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар бодит гүйцэтгэл, холбогдох нотлох баримтад үндэслэж бодитой үнэлээгүй, зөвхөн 2024 оны гүйцэтгэлээр тайлагнаж, үнэлсэн, хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр үнэлээгүй нь таван жилд тодорхойлсон бодлого, зорилго, зорилтыг хэрхэн хангаж байгаа, цаашлаад урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тодорхойлоогүй буюу зөвхөн богино хугацааны төлөвлөлтөд анхаардгийг харуулж байна.
6. Эдийн засаг, хөгжлийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар болон хэрэгжүүлэгч байгууллагууд төлөвлөсөн зорилт, арга хэмжээг хэдэн хувьтай хэрэгжүүлсэнд ач холбогдол өгч байгаагаас “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлснээр нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө бий болж байгааг тооцож үнэлээгүй нь хууль, эрх зүйн зохицуулалт дутагдалтай, уг үнэлгээг хийх тогтолцоо бүрдээгүйтэй холбоотой байна. Энэ нь шаардлагатай нэмэлт өөрчлөлт оруулах боломжийг хязгаарлаж, үр нөлөө багатай арга хэмжээг хэрэгжүүлж үргүй зардал гарах нөхцөлийг үүсгэж болзошгүй байна.
7. “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д тодорхойлсон зорилго, зорилт, арга хэмжээний хүрээнд 2021-2024 онд нийт **21.7** их наяд төгрөг зарцуулсан ч нийгэм, эдийн засагт ямар эерэг өөрчлөлт бий болсон нь тодорхойлогдохгүй байна.

ЗӨВЛӨМЖ

Монгол Улсын Их Хуралд толилуулах нь:

1. Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2, 9.2.3-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн Төсвийн тухай хуулийг батлахдаа тэдгээрийн хоорондын уялдаа, нийцэлд анхаарах,
2. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд туссан арга хэмжээг хугацаанд нь биелүүлээгүй хэрэгжүүлэгч байгууллагын удирдлагад хариуцлага тооцох хууль, эрх зүйн зохицуулалт, шалгуурыг тодорхой болгож, холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцох,
3. Хөгжлийн бодлогын баримт бичигт төсвийн ерөнхийлөн захирагчийн саналд үндэслээгүй, судалгаа, тооцоололгүй арга хэмжээг Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатанд нэмж баталдаг асуудлыг цаашид таслан зогсоохыг толилуулж байна.

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдад:

1. Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээнд хууль, журам, аргачлалд заасны дагуу судалгаа, тооцоо, үнэлгээг иж бүрэн хийх.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга нарт:

1. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлснээр бий болох үр нөлөөг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг тодорхой төлөвлөн, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж, тооцоо, судалгаанд үндэслэн бодитой, хэмжигдэхүйц, хэрэгжүүлэх хугацаа, хариуцах байгууллагыг тодорхойлж боловсруулах,
2. Хөгжлийн бодлого, төлөвлөлтөд оролцогч талуудын (Үндэсний статистикийн хороо, Монгол банк, Сангийн яам) хөгжлийн бодлого, төлөвлөлтийн талаарх хуулиар хүлээсэн чиг үүргийг хангуулах,
3. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд бодит гүйцэтгэл, нотлох баримтад суурилсан, цогц хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр хийж, урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тодорхойлж, хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллах,
4. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн гүйцэтгэлд нийгэм, эдийн засагт ямар үр нөлөө, эерэг өөрчлөлт бий болсныг үнэлж тооцон Үндэсний статистикийн хорооноос гаргадаг статистикийн өгөгдөлд оруулж, нийтэд ил тод, ойлгомжтой хэлбэрээр байршуулах ажлыг зохион байгуулах.

Монгол Улсын Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд, Сангийн сайд нарт:

1. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг тодорхойлж, хангах хуульд заасан чиг үүргийн хүрээнд төсөл, арга хэмжээний тоо, санхүүжилтийн зохистой харьцааг бодитой тооцож төлөвлөх, санхүүжилтийн эх үүсвэр нь бүрэн шийдэгдээгүй асуудалд дүн шинжилгээ хийж, шаардлагатай зохицуулалтын арга хэмжээ авах,
2. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон тухайн жилийн Төсвийн тухай хуульд туссан арга хэмжээний нийцэлд

хууль тогтоомжийн хүрээнд тусгасан ялгаатай шаардлагад дүн шинжилгээ хийж, холбогдох арга хэмжээ авах, шийдвэр гаргах этгээдэд уламжлах.

Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийг хэрэгжүүлснээр бий болох үр нөлөөг тодорхойлж, түүнд чиглэсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг төлөвлөн, хууль тогтоомжид заасан шаардлагыг тооцоо, судалгаанд үндэслэн бодитой, хэмжигдэхүйц тодорхойлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагын санал, тооцооллыг нэгтгэн боловсруулах,
2. Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд бодит гүйцэтгэл, нотлох баримтад суурилсан, цогц хяналт-шинжилгээ, үнэлгээг хөтөлбөр хэрэгжсэн хугацааны нэгдсэн дүнгээр хийж, урт, дунд хугацааны баримт бичгийн зорилго, зорилт хүрэх үр дүнгийн хэдэн хувьд хүрснийг тодорхойлж, тайлагнах,
3. Монгол Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээнд хууль, журам, аргачлалд заасны дагуу судалгаа, тооцоо, үнэлгээг иж бүрэн хийж, орон нутгийн иргэдийн саналыг авч, олон нийтээр хэлэлцүүлэх.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Эдийн засаг, хөгжлийн яамны ирүүлсэн санал


**МОНГОЛ УЛСЫН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ**
Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас/Факс: (976-51) 26 33 33,
Цахим шуудан: info@med.gov.mn

2025.03.11 № 03/634

танай _____ -ны № _____ -т

┌ **МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ** ┐
└ **АУДИТОРЫН ОРЛОГЧ** ┘
Я.САМБУУНЯМ ТАНАА

Танай байгууллагаас Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8.1, Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа.

Тус тайлангийн төсөлд тусгайлан хүргүүлэх саналгүй болно.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

И.БАТХҮҮ

250247

Аудитын тайлангийн төсөлд санал авахаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн боловч Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй тул мөн хуулийн 18.4-т заасныг үндэслэн саналгүйд тооцсон болно.

Улсын Их Хурлын хэлэлцүүлгийн шатанд нэмэгдсэн төсөл, арга хэмжээ

№	Арга хэмжээний нэр	Шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон эсэх
1	Төрийн өмчит их сургуулийн засаглалыг төрөөс хараат бус болгож, эрх зүйн орчныг сайжруулан судалгааны их сургууль болгоно.	Байхгүй
2	Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана.	Дээд боловсролын нийт багшид докторын зэрэгтэй багшийн эзлэх хувь
3	Олон улсад өрсөлдөж чадахуйц үндэсний боловсролын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлнэ.	Байхгүй
4	Хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгах чиглэлээр эрх зүйн орчныг чангатгаж, хэрэгжилтэд хатуу хяналт тавих тогтолцоог бий болгоно.	Байхгүй
5	Эрдэм шинжилгээний байгууллага, их сургуулийн хамтарсан “Үндэсний судалгааны төв”-үүдийг байгуулах замаар нөөцийг төвлөрүүлж, эрдэм шинжилгээний ажлын зардлыг нэмэгдүүлэн зөв ашиглаж, судалгааны ажлын нийгэм, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлнэ.	Шинэ бүтээлийн гэрчилгээ авсан бүтээлийн тоо
6	Хэмжил зүйн лабораторийг олон улсын жишигт хүргэсэн байна.	Байхгүй
7	Шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг их, дээд сургуулийн сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацын төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулна.	Шинжлэх ухаан, технологийн судалгаа, туршин нэвтрүүлэх санхүүжилтийн дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь
8	Хүн амын удмын сан, нөхөн үржихүйг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн орчныг бий болгоно.	Байхгүй
9	Хоршооны тогтолцоо, эрх зүйн орчныг боловсронгуй болгож, ажилгүйдэл, ядуурлыг бууруулахад дорвитой хувь нэмэр оруулна.	Ажилгүйдлийн түвшин, Ядуурлын түвшин
10	Хоол, хүнсний тухай боловсрол олгох талаар сургалтын хөтөлбөрт тусгана.	Иргэдийн эрүүл мэндээс шалтгаалсан санхүүгийн бэрхшээл, ядууралд өртөх эрсдэлийг бууруулсан хувь
11	Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ.	Байхгүй
12	Эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ.	Шинээр баригдах төмөр замын урт Шинээр баригдах улсын чанартай авто замын урт Уул уурхайн салбарын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь
13	Завхан, Говь-Алтай аймгуудын эрчим хүчний дутагдлыг арилгах зорилгоор шаардлагатай агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийн шинэчлэл, барилгын ажлыг хэрэгжүүлнэ.	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь
14	Арц суурь боомтыг Нөмрөг сумтай, Улиастай хотыг Алтай хоттой холбосон автозамуудыг барина	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн хэрэгжилт

15	Эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий системийг бүрдүүлнэ.	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь
16	Экспортыг дэмжих, худалдааг хөнгөвчлөхөд стандартчилал, тохирлын үнэлгээний бодлогоор дэмжлэг үзүүлнэ.	Олон улсын түвшинд нийцүүлж шинэчилсэн үндэсний стандартын тоо
17	XXI зууны төрийн удирдлагын шинэ арга барил болох гурван тулгуурт хөгжлийн онолын дагуу улс төр, нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд гурван талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлнэ.	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Засгийн газрын үр нөлөө
18	Гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ.	Байхгүй
19	Төрийн үйл ажиллагааны бүхий л шатанд Шилэн дансны тухай болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах замаар иргэдийн мэдээлэл авах эрхийг дээдлэн ажиллаж, холбогдох хуулийн дагуу иргэний шаардсан мэдээллийг гаргаж өгөөгүй төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчийн байгууллагуудын удирдлагад хариуцлага тооцдог болно	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Иргэдийн дуу хоолой ба хариуцлага
20	Хилийн чанадад байгаа иргэдийн эрх ашгийг хамгаалах, улс төрийн болон бусад эрхээ хэрэгжүүлэх, монгол хүүхэд эх хэлээрээ сурч боловсрох боломжийг бий болгосон эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.	Байхгүй
21	Аймгийн төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж байгуулна.	Хот, суурин газрын тогтмол цуглуулж, шаардлага хангасан байдлаар устгах хог хаягдлын эзлэх хувь
22	Гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.	байхгүй
23	Үндэсний аюулгүй байдлыг хангах үүднээс стратегийн зориулалттай нөөцийн бараа, материалын нэр төрөл, тоо хэмжээг нэмэгдүүлж, бараа материалын хадгалалт, хамгаалалтыг сайжруулж, хөргүүр бүхий автоматжуулсан махны зоорь, хүнсний бүтээгдэхүүн хадгалах зориулалт бүхий иж бүрэн механикжуулсан хүнсний агуулах, газрын тосны бүтээгдэхүүнийг хадгалах зориулалттай агуулахын цогцолбор байгуулна.	байхгүй
24	Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Хуулийн засаглал
25	Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд эхний ээлжид алслагдсан зарим аймгуудад гадаадын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр “Аймаг, сумын төвийн бүсчилсэн хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийг Баян-Өлгий, Увс, Ховд, Дорнод аймгуудад хэрэгжүүлнэ.	Байхгүй
26	Ховд аймгийн Ховд, Эрдэнэбүрэн, Чандмань, Дөргөн, Дарви, Хөшөөтийн чиглэлийн 160 км хатуу хучилтай автозамыг барих ажлын эхлүүлнэ.	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт
27	Өвөрхангай аймгийн Арвайхээр-Хужирт-Бат-Өлзий чиглэлийн аялал жуулчлалын зам, Өвөрхангай аймгийн Арвайхээр-Баянгол, Дундговь аймгийн Сайхан-Овоо, Өмнөговь аймгийн Цогт-Овоо чиглэлийн босоо тэнхлэгийн ачаа тээврийн замуудын зураг төслийг боловсруулан, барьж эхлүүлэх ба баруун бүсийн А0301, А0302 замын дагуух сумдыг улсын чанартай автозамтай үе шаттай холбох ажлын эхлүүлнэ	Шинээр баригдах улсын чанартай авто замын урт

28	Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зорилго бүхий төрийн, орон нутгийн төсвийн санхүүжилтээр болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагаа, төлөвлөлт, явц, үр дүн, зээл тусламжийн олголт нь зорилтот бүлэгтээ бодитой чиглэн ажиллаж чадаж байгаа эсэхэд тогтмол хяналт тавих гурван талт түншлэлийн механизмыг бий болгож ажиллуулна	Байхгүй
29	Цахим эдийн засаг, үйлчилгээний салбарыг дэмжихэд шаардлагатай дэд бүтэц болох Улаанбаатар хотын дагуул хотыг барьж байгуулна.	Хотын хөгжлийн үзүүлэлт
30	Шүүх засаглалыг улс төр, бизнесийн бүлгийн ашиг сонирхлоос ангид, хараат бус байлгаж, шүүхийн үйл ажиллагаанд шударга ёсыг тогтоож, иргэдийн итгэлийг сэргээж ажиллана	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Хуулийн засаглал
31	Хууль сахиулах байгууллагууд иргэдийн өргөдөл, гомдлыг шуурхай хянан шийдвэрлэх, түүнд хяналт тавих цахим нэгдсэн сүлжээнд бүрэн холбогдож, иргэдэд үйлчлэх таатай орчныг бүрдүүлнэ	Байхгүй
32	Хөдөө орон нутагт жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, ажлын байр бий болгох, малын үүлдэр, угсааг сайжруулах, малын гаралтай түүхий эдийн үйлдвэрлэгчдийг дэмжих “Шинэ хөдөө” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ	Байхгүй
33	Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, эрчимжсэн мал аж ахуйг хөгжүүлнэ	Байхгүй
34	Улс, орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь
35	Нийгэм, эдийн засаг, бизнесийн бүхий л харилцаа, засаглалын бүх шатанд олон талт түншлэлийг оновчтой, үр дүнтэй нэвтрүүлнэ	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Зохицуулалтын чанар
36	Малын гаралтай түүхий эд боловсруулах, экспортлох үйлдвэр, технологийн парк байгуулж, ажлын байрыг шинээр бий болгож, малчдын орлогыг өсгөнө	Шинээр байгуулагдах хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийн тоо
37	Малчид, иргэдийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг дээшлүүлэх зорилгоор хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний үнэ цэнийг нэмэгдүүлэн экспортлох чиглэлийн боловсруулах үйлдвэрүүдийг богино хугацаанд барьж ашиглалтад оруулна	Шинээр байгуулагдах хөдөө аж ахуйн үйлдвэрлэл технологийн паркийн тоо
38	Дархан, Эрдэнэт болон бусад том хотуудыг улсын зэрэглэлтэй болгож, хөрөнгө оруулалт, ажлын байрыг нэмэгдүүлэх хууль, эрх зүйн таатай орчныг бүрдүүлнэ	Ажилгүйдлийн түвшин
39	Баянтээг нүүрсний уурхайг түшиглэн 20 МВт-ийн цахилгаан станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөн, хөрш зэргэлдээх аймгуудын түлшний хэрэгцээг хангаж, агаарын бохирдлыг бууруулна	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь
40	Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлж, архидан согтуурахтай тэмцэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлнэ	Дэлхийн банкны засаглалын үзүүлэлт: Хуулийн засаглал
41	Аймаг, сумын төвийг бүсчилсэн ногоон хөгжлийн хөрөнгө оруулалтын хөтөлбөрт хамруулж, сумдад “Сумын хөгжил” арга хэмжээг хэрэгжүүлнэ	Сумын төвийн хөгжлийн хөтөлбөр хэрэгжсэн сумын төвийн тоо

“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн арга хэмжээний хэрэгжилт

№	ТЕЗ	Арга хэмжээний нэр
1. "Үр дүнтэй" арга хэмжээний жагсаалт		
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ		
1	БЯ	2.1.1.сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн насыг 3-5 болгож, 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.
2	БЯ	2.1.2.ерөнхий боловсролын сургалтын чанарын үндэсний үнэлгээг жил бүр хийж, олон улсын үнэлгээнд хамруулна.
3	БЯ	2.1.5.хөгжлийн тэргүүлэх чиглэл болон эрэлттэй мэргэжлээр суралцаж байгаа сургалт, судалгааны ажлын амжилтаар тэргүүлэгч оюутнуудад сургалтын төлбөрийн бүрэн тэтгэлэг олгоно.
4	БЯ	2.1.6.Засгийн газрын тэтгэлгээр дотоод, гадаадад суралцагчидтай гэрээ хийж, хөдөлмөрийн зах зээлийн захиалгатай уялдуулан мэргэжлээр нь томилон ажиллуулдаг болгоно.
5	БЯ	2.1.7.багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг бодитой болгож, нийгмийн баталгааг хангана.
6	БЯ	2.1.8.газар зүйн мэдээллийн системд үндэслэн сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтоож, хүн амын өсөлтийн хэтийн төлөвтэй уялдуулан хүртээмжийг нэмэгдүүлэн, тэгш байдлыг хангах тогтолцоог бэхжүүлнэ.
7	БЯ	2.1.10.цахим, зайн сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлагыг тогтоон, сургалтын платформыг хөгжүүлэн багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа сургалтын хөтөлбөр насан туршийн тогтолцоог бэхжүүлнэ.
8	БЯ	2.1.11.боловсролын удирдлагын мэдээллийн системийг бүх түвшинд хөгжүүлж, бусад салбарын мэдээллийн сантай холбон, бодлого, төлөвлөлт, статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээнд ашиглан, боловсролын үйлчилгээг цахимжуулна.
9	ГБХНХЯ	2.3.2.хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлнэ.
10	ГБХНХЯ	2.3.4.хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.
11	ГБХНХЯ	2.3.5.хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгах чиглэлээр эрх зүйн орчныг чангатгаж, хэрэгжилтэд хатуу хяналт тавих тогтолцоог бий болгоно.
12	ЭЗХЯ	2.4.4.шинэ мэдлэг, патентыг үйлдвэрлэлд нэвтрүүлэн эдийн засгийн эргэлтэд оруулах, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг татварын бодлого, эдийн засгийн хөшүүргээр дэмжсэн эрх зүйн шинэчлэлт хийгдэнэ.
13	ЭЗХЯ	2.4.6.эрдэм шинжилгээний ажилтны мэдлэг чадвар, бүтээлийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг олон улсын үнэлгээний жишигт нийцүүлж, үр дүнд тохирсон цалин, урамшууллын тогтолцоог бүрдүүлсэн байна.
14	ГБХНХЯ	2.6.2.ажилгүйдлийн даатгалын тогтолцоо боловсронгуй болж, хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг үр дүнд суурилсан санхүүжилтийн арга хэлбэрийг нэвтрүүлэн ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлнэ.
15	ГБХНХЯ	2.6.5.төрийн албан хаагчдын цалинг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.

ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА		
16	ГБХНХЯ	3.1.1.нийгмийн даатгалын хууль тогтоомжийг шинэчилж даатгуулагч олон эх үүсвэрээс тэтгэвэр авах нөхцөл бүрдэн, хуримтлалын нэгдсэн сан байгуулагдан иргэд бодит хуримтлалтай болох эрх зүйн шинэчлэл хийгдэнэ.
17	ГБХНХЯ	3.1.2.иргэн бүр нэрийн дансандаа бодит хуримтлалтай болж, дансны үлдэгдлийн тодорхой хувийг гэр бүлдээ өвлүүлэх нийгмийн даатгалын шинэчлэл хийгдэнэ.
18	ГБХНХЯ	3.1.5.нийгмийн даатгалын сангийн болон халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг инфляцын түвшин болон хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нэмэгдүүлнэ.
19	БЯ, ХХААХҮЯ	3.5.5.хоол, хүнсний тухай боловсрол олгох талаар сургалтын хөтөлбөрт тусгана.
20	ШСАА	3.6.6.хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан бүсчилсэн хөгжлийн бодлого, бүс нутгийн оновчтой бүтэц, хөгжлийн ирээдүйтэй сууринг тодорхойлж, орон зайн төлөвлөлтийг хийнэ.
ДӨРӨВ.ЭДИЙН ЗАСАГ		
21	ЭЗХЯ, ГБХНХЯ	4.1.4.эдийн засаг жил бүр тогтвортой өсөж, ажил эрхлэлтийг тасралтгүй нэмэгдүүлнэ.
22	ЭХЯ	4.2.14.Завхан, Говь-Алтай аймгуудын эрчим хүчний дутагдлыг арилгах зорилгоор шаардлагатай агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийн шинэчлэл, барилгын ажлыг хэрэгжүүлнэ.
23	СЯ, АҮЭБЯ	4.6.1.хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлсэн байна.
ТАВ.ЗАСАГЛАЛ		
24	ЭЗХЯ	5.2.3.гадаад хөрөнгө оруулалт, худалдааг дэмжсэн төрийн зохицуулалтыг боловсронгуй болгож, нэг цонхны нэгдмэл бодлого хэрэгжүүлж хэвшинэ.
25	ЦХИХХЯ	5.3.2.цахим мэдээллийн нэгдсэн сан, дэд бүтэц бий болгож хөгжүүлэх нэгдсэн бодлого, төлөвлөлттэй болгоно.
26	ЦХИХХЯ	5.3.3.төрийн байгууллага хоорондын болон төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын мэдээллийн солилцоо сайжирч, захиргааны зардал бууран, үйлчилгээний үр дүн сайжирна.
27	ЦХИХХЯ	5.3.4.төрийн байгууллагын мэдээллийн ил тод байдал нэмэгдэж, иргэд, олон нийтийн саналыг цахимаар авах нөхцөлийг бүрдүүлнэ.
28	ТАЗ	5.4.7.орон нутагт томилогдон ажиллаж байгаа төрийн албан хаагчдын нийгмийн асуудлыг сайжруулна.
ДОЛОО.АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ		
29	ХЗДХЯ	7.2.4.гадаадын иргэдийг улсын хилээр нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч, нэгдсэн санд бүртгэх тогтолцоог бүрдүүлнэ.
30	ХЗДХЯ	7.4.5.мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.
31	ХЗДХЯ	7.4.6.хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
ЕС.УЛААНБААТАР БА ДАГУУЛ ХОТ		
32	ГБХНХЯ, НЗДТГ	9.1.1.нийгмийн үйлчилгээний байгууллагуудын (сургууль, цэцэрлэг, эрүүл мэнд, биеийн тамир, спортын байгууллага, залуучууд хөгжлийн төв, хүүхэд хамгаалах төв, асрамжийн газар гэх мэт) хүчин чадал, хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.
33	НЗДТГ	9.2.4.олон улсын стандартад нийцсэн унадаг дугуйн болон явган хүний зам барьж, иргэдэд ая тухтай зорчих боломжийг нэмэгдүүлнэ.
34	НЗДТГ	9.3.2.хот дахин хөгжүүлэх төслийн хүрээнд орон сууцны хангамжийг нэмэгдүүлнэ.

35	НЗДТГ	9.4.2.Нийслэл эдийн засгийн хувьд бие даан хөгжих эрх зүйн орчныг бүрдүүлнэ.
36	ЗТЯ, ХББОСЯ	9.5.2.Зүүн хойд Азийн зорчигч, ачаа тээврийн нэгдсэн зангилаа төв болгох ажлыг эрчимжүүлж, Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх онгоцны буудлыг ашиглалтад бүрэн оруулна.
2. "Тодорхой үр дүнд хүрсэн" арга хэмжээний жагсаалт		
НЭГ.ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ		
37	ССАЖЗЯ	1.1.1.уран бүтээл, утга зохиолд үндэсний бахархлыг сэргээх агуулгыг тусгаж, Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх эх оронч үзлийг сэргээнэ.
38	ССАЖЗЯ	1.1.2.үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгоно.
39	ССАЖЗЯ	1.1.4.соёлын өвийг хамгаалах тогтвортой механизм бүрдүүлнэ.
40	ССАЖЗЯ	1.2.1.өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай монгол хүнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх цогц арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.
41	ССАЖЗЯ	1.2.2.нүүдлийн соёл, иргэншлийн судалгааны төв байгуулах ажлыг эхлүүлсэн байна.
42	ССАЖЗЯ	1.2.4.хүүхдийн соёлын өв, хөгжлийн төвийг байгуулах ажлыг эхлүүлнэ.
43	БЯ	1.3.1.бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлнэ.
44	БЯ, ССАЖЗЯ	1.3.2.Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ.
45	ССАЖЗЯ	1.4.2.олон улсын монгол судлалын тэргүүлэх чиглэлийн судалгааны үр дүнг түгээн дэлгэрүүлж, нийтийн хүртээл болгоно.
46	ССАЖЗЯ	1.5.2.хилийн чанадад байгаа Монгол Улсын соёлын өвийг бүртгэх ажлыг зохион байгуулна.
ХОЁР.ХҮНИЙ ХӨГЖИЛ		
47	БЯ	2.1.3.Монголын түүх, хэл, соёл, зан заншил, эх оронч сэтгэлгээ, үндэсний өв уламжлал, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн агуулгаар баяжуулсан Монгол хүний хүмүүжлийг дээдэлсэн сургалтын хөтөлбөрийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр бүх шатны боловсролын байгууллагад хэрэгжүүлнэ.
48	БЯ	2.1.4.төрийн өмчит их сургуулийн засаглалыг төрөөс хараат бус болгож, эрх зүйн орчныг сайжруулан судалгааны их сургууль болгоно.
49	БЯ	2.1.9.цэцэрлэг, дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг хоёр дахин нэмэгдүүлж, ерөнхий боловсролын сургуульд "Үдийн хоол" үйлчилгээг бүрэн нэвтрүүлнэ.
50	БЯ	2.1.12.олон улсад өрсөлдөж чадахуйц үндэсний боловсролын тогтолцоог үе шаттайгаар нэвтрүүлнэ.
51	ЭМЯ	2.2.1.халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, илрүүлэх тогтолцоог үндэсний түвшинд шинэчлэн, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын бэлэн байдал, хариу арга хэмжээний тогтолцоог бэхжүүлнэ.
52	ЭМЯ	2.2.2.хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, үндэсний түвшинд нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний тогтолцоог бэхжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшнийг бууруулна.
53	ЭМЯ	2.2.4.яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг үндэсний түвшинд сайжруулж, парк шинэчлэлийг хийнэ.
54	ЭМЯ	2.2.6.эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.
55	ЭМЯ	2.2.7.эм, эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангах, хангамж хүртээмжийг нэмэгдүүлэх хяналтын тогтолцоог бүрдүүлнэ.

56	ЭМЯ	2.2.8.эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.
57	ГБХНХЯ	2.3.1.хүн амын тогтвортой өсөлтийг дэмжсэн, судалгаа, нотолгоонд суурилсан, гэр бүлд ээлтэй хөгжил, хамгааллын үр ашигтай тогтолцоог бүрдүүлнэ.
58	ГБХНХЯ	2.3.3.залуу гэр бүлийг дэмжсэн орчин нөхцөл сайжирна.
59	ЭЗХЯ	2.4.1.шинжлэх ухаан, технологи, инновацын салбарын судалгаа, шинжилгээний чиглэлийг оновчтой болгон, эрдэм шинжилгээ, судалгаанд зарцуулах төсвийн зардлыг үе шаттай нэмэгдүүлнэ.
60	ЭЗХЯ	2.4.2.шинжлэх ухаан, технологи, инновацын хүний нөөцийг үе шаттай бэлтгэх, чадавхжуулах нэгдсэн бодлого хэрэгжүүлж, эрдэм, шинжилгээний ажилтны тоог нэмэгдүүлнэ.
61	ЭЗХЯ	2.4.7.шинжлэх ухаан, технологи, инновацын статистик мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний тогтолцоог олон улсын нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоно.
62	СХЗГ	2.4.8.хэмжил зүйн лабораторийг олон улсын жишигт хүргэсэн байна.
63	ЭЗХЯ	2.4.9.шинжлэх ухааны байгууллагуудын бүтээл, судалгааны үр дүнг их, дээд сургуулийн сургалтад ашигладаг механизмыг бүрдүүлж, сургалт, судалгаа, инновацын төвүүдийг их, дээд сургуулиудад байгуулна.
64	ХХААХҮЯ	2.5.5.хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог бэхжүүлнэ.
65	ГБХНХЯ	2.6.3.оюуны хөдөлмөрийг дэмжсэн цахим, зайн ажлын байрыг нэмэгдүүлнэ.
66	ЭМЯ	2.7.2.цус ойртолтоос сэргийлж, удамшлын өвчин болон төрөлхийн согогтой хүүхдийн эрт оношилгооны чадавхыг дээшлүүлнэ.
67	ХЗДХЯ	2.7.3.гадаадын иргэн, харьяалалгүй хүн, цагаачдын тооны зохист түвшнийг хадгалах, хяналт тавих тогтолцоог бэхжүүлнэ.
ГУРАВ.АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА		
